



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

418. Чиглэл өгөх тухай Дугаар 106 1705

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

419. “Цахим засаг” үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 101 1706

420. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 131 1729

421. Журам батлах тухай Дугаар 133 1729

422. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай Дугаар 136 1738

423. Хөдөө аж ахуйн ээлжит тоолого явуулах тухай Дугаар 137 1739

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 06 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2, Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 7, Соёлын өвийг хамгаал ах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8, 13 дугаар зүйлийн 13.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалан, хамгаалах зорилгоор:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн археологи болон палеонтологийн малтлага, судалгааны ажлын болон олдворуудын нэгдсэн судалгааг гаргах, каталогжуулан Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгүүлэх, зарим дурсгалт газрыг Дэлхийн байгалийн болон соёлын өвийн жагсаалтад бүртгүүлэх;



2. Хууль бусаар хилийн чанадад гарсан Монгол Улсаас гаралтай, монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйлсийг эх орондоо эргүүлэн авчрах, энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох олон улсын конвенцид нэгдэн орох, шаардлагатай тохиолдолд гадаад улсын шүүхэд нэхэмжлэл гаргах замаар үндэсний баялаг, төрийн өмчийг хамгаалах арга хэмжээ авах;

3. Хил хамгаалах болон гаалийн байгууллагын түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтыг чангатгах, зориулалтын техник хэрэгслээр хангах, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Батболд/-т чиглэл болгосугай.

Хоёр. Зарлигийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлаж, хэрэгжилтийн талаар улирал бүр тогтмол мэдээлж байхыг Засгийн газар/С.Батболд/-т чиглэл болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 4 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 101

Улаанбаатар
хот

“Цахим засаг” үндэсний хөтөлбөр батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 5.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр, “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох



гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2012 оны 101 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

“ЦАХИМ ЗАСАГ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн бодлого боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй болгож, цахим засгийн үйлчилгээг хөгжүүлж нэвтрүүлэх зорилгоор “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг боловсруулж байна.

Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Засгийн газраас батлагдсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр, Монгол Улсад бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн, хөгжиж байгаа орнуудад цахим засгийг хөгжүүлэх талаар Дэлхийн банкнаас гаргасан зөвлөмж, судалгааг энэхүү хөтөлбөрийг боловсруулахад үндэслэл болгов. Хөтөлбөрийг боловсруулах явцад цахим засгийг хөгжүүлэн, амжилттай хэрэгжүүлж байгаа АНУ, ХБНГУ, БНСУ, Малайз Улс, Шинэ Зеланд Улс, Япон Улс, БНЭУ зэрэг орны туршлагыг судалсан болно.

Цахим гарын үсгийн тухай хууль, “Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 61 дүгээр тогтоол гарсан нь цахим хэлбэрээр мэдээлэл солилцох харилцааг хангах, цахим засгийг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх анхны алхам болсон.



Манай улсын 170 сум, суурин газар 21000 км орчим өндөр хурдны шилэн кабелийн сүлжээгээр холбогдсон бөгөөд ойрын жилүүдэд бүх сум, суурин газрыг шилэн кабелиар бүрэн холбохоор ажиллаж байна. 2011 оны байдлаар гаргасан судалгаагаар төрийн байгууллага албан ажлын хэрэгцээнд нийт 56000 гаруй компьютер ашиглаж байна. Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын аж ахуйн нэгж, байгууллагад 82 мянга орчим хүн ажиллаж, ойрын 5 жилд улсын хэмжээнд мэдээллийн технологи, харилцаа холбооны мэргэжилтний эрэлтийн өсөлт дунджаар 15 хувь байхад энэ чиглэлээр бэлтгэгдэж байгаа мэргэжилтний өсөлт дөнгөж 4 хувь байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Мөн мэдээллийн технологийн өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн салбарын ажилтны мэргэжлийн ур чадварыг сайжруулах шаардлагатай байна.

Цаашид төрийн байгууллагыг шилэн кабелийн сүлжээгээр холбосон нэгдсэн сүлжээ бий болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, нийт ашиглагдаж байгаа компьютерийн 50-иас доошгүй хувийг шинэчлэх, программ хангамжийг лицензтэй болгох, мэдээллийн систем, контентийг хөгжүүлэх, хүний нөөц, мэдээллийн технологийн менежментэд шинэчлэл хийх зэрэг арга хэмжээ авснаар цахим засгийн үйлчилгээг иргэдэд хүргэх нөхцөл бүрдэх юм. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн түгээмэл хэрэглээ болсон хөдөлгөөнт холбоонд суурилсан цахим засгийн үйлчилгээг нэвтрүүлснээр иргэн бүр хэрэгцээтэй үйлчилгээг шууд гар дээрээсээ хүртэх бүрэн боломжтой болох юм.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэ хөтөлбөрт хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Цахим засаг” (Electronic Government, E-Gov) гэж төрийн үйл ажиллагааг иргэдэд ил тод мэдээлэн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хамтын ажиллагааг хангах, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаанд мэдээллийн технологи, харилцаа холбооны дэвшилтэт технологийг ашиглах замаар цахим үйлчилгээг тулгуур болгон улс орны дотоод, гадаад харилцаа, засаглалын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах үйл явцыг;

2.1.2. “Засгийн газрын энтерпрайз архитектур” (Government Enterprise Architecture) гэж цахим засгийг бий болгох үйл явцад чиглэгдсэн стандарт, харилцан уялдаа бүхий бизнес архитектур, мэдээллийн архитектур, шийдлийн архитектур, техник, технологийн архитектур зэргээс бүрдсэн үр ашигтай системийн шийдлийг;



2.1.3. “Мэдээллийн технологийн дэд бүтэц” гэж мэдээллийн сүлжээ, техник (хатуу) болон программ хангамж, мэдээллийн сан, мэдээллийн системийн загвар (зөөлөн) зэргийг;

2.1.4. “Хөдөлгөөнт холбоо” гэж утасгүй зөөврийн харилцаа холбооны төхөөрөмж (гар утас, таблет гэх мэт)-ийг ашиглан мэдээлэл солилцохыг;

2.1.5. “Үүлэн тооцоолол” гэж компьютер болон бусад төхөөрөмж нь программ хангамж, дундын өгөгдөл, мэдээллийг интернэтийн орчинд дамжуулан боловсруулдаг тооцооллыг.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн зарчим,
хамрах хүрээ, хугацаа

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь үндсэн зарчмыг баримтална:

3.1.1. төрийн байгууллагын мэдээллийн систем нь Засгийн газрын нэгдсэн энтерпрайз архитектурт нийцсэн, үр ашигтай, өгөөжтэй, уян хатан байх;

3.1.2. лицензтэй программ хангамжийг хэрэглэх, зохиогчийн эрхийг хүндэтгэх ёс зүйг эрхэмлэх;

3.1.3. төрийн цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байх;

3.1.4. төрийн байгууллагын мэдээллийн технологийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх нэгдсэн бодлоготой байх;

3.1.5. хөдөлгөөнт холбооны технологид суурилсан төрийн үйлчилгээг түлхүү дэмжих;

3.1.6. төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих;

3.1.7. хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлоготой байх.

3.2. Хөтөлбөрийг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт төрийн байгууллага, иргэдийг хамруулж хэрэгжүүлнэ.

3.3. Хөтөлбөрийг 2012-2016 онд хэрэгжүүлнэ.



Дөрөв. Хөтөлбөрийн зорилго, зорилт

4.1. Төрийн байгууллагыг холбосон мэдээллийн технологийн дэд бүтцийг байгуулан мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглах замаар төрийн бодлого боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, мэдээ, мэдээллийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэж, төрийн ой санамжийг төгөлдөржүүлэх, түүнд суурилсан цахим засгийн үйлчилгээг хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

4.2. Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хангахад дараахь зорилтуудыг дэвшүүлж байна:

4.2.1. Нэгдүгээр зорилт: Цахим засгийг хөгжүүлэх бодлого зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

4.2.2. Хоёрдугаар зорилт: Мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх;

4.2.3. Гуравдугаар зорилт: Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох;

4.2.4. Дөрөвдүгээр зорилт: Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн цахим үйлчилгээг ашиглах мэдлэг иргэдэд олгох.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Цахим засгийг хөгжүүлэх бодлого зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1.1. мэдээллийн болон кибер орчны аюулгүй байдлыг хангах, бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох, цахим үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбогдох нийгмийн харилцааг зохицуулан, цахим засгийг хөгжүүлэх чиглэлээр шаардагдах хуулийн төсөл боловсруулах, одоо мөрдөгдөж байгаа зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

5.1.2. цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээний чанарыг сайжруулах, сүлжээний



зохион байгуулалтыг боловсронгуй болгох, мэдээлэл хадгалах, хамгаалах, ашиглахтай холбогдсон цахим засгийг хөгжүүлэхэд шаардлагатай стандарт, дүрэм, журмыг боловсруулан батлуулах;

5.1.3. төрийн байгууллагад ашиглагдах программ хангамж, мэдээллийн систем боловсруулах, нэвтрүүлэх, тэдгээрийн мэдээлэл хадгалалт, хамгаалалт, ашиглалт, мэдээллийн технологийн аудит хийх тогтолцоог бий болгох, хүний нөөцийн хөгжлийн талаар баримтлах чиглэл боловсруулан хэрэгжүүлэх;

5.1.4. цахим засгийн үйлчилгээг найдвартай, аюулгүй явуулах программ хангамж, контентийг хөгжүүлэх бодлого зохицуулалтын таатай орчин бүрдүүлэх.

5.2. Мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх хоёрдугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.2.1 төрийн байгууллагыг холбосон өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх, нөөц сүлжээ үүсгэх;

5.2.2. утасгүй өргөн зурвасын сүлжээг бий болгож өргөтгөх үйл ажиллагааг дэмжих;

5.2.3. нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгох;

5.2.4. Засгийн газрын нэгдсэн энтерпрайз архитектур боловсруулж, нэвтрүүлэх;

5.2.5. мэдээллийн нууцлал, хамгаалалтын системийн нэгдсэн төлөвлөлт, дизайн боловсруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;

5.2.6. төрийн бүх байгууллагын программ хангамж, үйлдлийн системийг үе шаттайгаар лицензтэй болгох;

5.2.7. технологийн шинэчлэл, үүлэн тооцооллын технологи нэвтрүүлж эхлэх.

5.3. Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох гуравдугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



5.3.1. төрийн байгууллагын вэбсайтын контентийн чанарыг сайжруулж, тухай бүрт нь баяжилт, шинэчлэлт хийж хэвших;

5.3.2. төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг илүү хяналттай, өндөр бүтээмжтэй болгох зорилгоор гүйцэтгэлд тулгуурласан үнэлгээний мэдээллийн системийг нэвтрүүлэх;

5.3.3. эрэлт ихтэй, иргэдэд чирэгдэл учруулан ачааллыг үүсгэдэг төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх;

5.3.4. хөдөлгөөнт холбооны технологид суурилсан төрийн үйлчилгээг өргөтгөн, хөгжүүлэх;

5.3.5. төрийн үйл ажиллагааны талаар иргэд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, иргэдийн оролцоог хангах, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх, хариу өгөх цахим үйлчилгээг бий болгох;

5.3.6. мэдээллийн технологийн нэг цэгийн үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх

5.4. Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн цахим үйлчилгээг ашиглах мэдлэг иргэдэд олгох дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.4.1. төрийн албан хаагчдад зориулсан мэдээллийн технологийн байнгын сургалт болон мэдлэг, ур чадварыг дээшлүүлж сургалт зохион байгуулах;

5.4.2. мэдээллийн технологийн мэргэжилтэн, мэргэжлийн багш нарын мэдлэг, ур чадварыг олон улсын түвшинд хүргэх, орон нутагт мэргэжлийн боловсон хүчнээр хангах;

5.4.3. төрийн байгууллагад ажиллаж байгаа мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтний ур чадварыг сайжруулан, тогтвортой ажиллах урамшууллын механизм бий болгох;

5.4.4. мэдээллийн технологийн нарийн мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх;

5.4.5. цахим засгийн үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээний ажлыг бүх талаар дэмжих;



5.4.6. иргэд болон төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтыг төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, их, дээд сургуулиудтай хамтран зохион байгуулах;

5.4.7. ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт мэдээллийн технологийн сургалтын агуулгыг нэмэгдүүлэх;

5.4.8. гэрийн ажилтай эмэгтэйчүүд, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандсан цахим болон явуулын сургалт зохион байгуулах.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, хүлээх үүрэг

6.1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь цахим засгийг хөгжүүлэхэд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны харилцан уялдаа, хамтын ажиллагааны нэгдмэл байдлыг хангах ажлыг зохион байгуулах.

6.2. Санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авах.

6.3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь сургалтын хөтөлбөрт холбогдох өөрчлөлтийг оруулах, мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, судалгаа шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх.

6.4. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх.

6.5. Үндэсний хөгжил, шинэтгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төсөл хөтөлбөрийг ач холбогдол, гарах үр дүнгээр нь эрэмбэлж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах, бусад салбарын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, хөгжлийн бодлоготой уялдуулах.



6.6. Төрийн захиргааны бусад байгууллага нь хариуцах асуудлынхаа хүрээнд цахим засгийг хөгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, шаардагдах хөрөнгө оруулалтыг улсын төсөв болон санхүүжилтийн бусад эх үүсвэрт тусган шийдвэрлүүлэх.

6.7. Бүх шатны Засаг дарга:

6.7.1. хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах;

6.7.2. хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдан зохион байгуулж, үр дүнгийн тухай тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх.

Долоо. Удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавин үнэлгээ хийж, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулна.

7.2. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байна.

Найм. Хөтөлбөрийн санхүүжилт, хүрэх үр дүн

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.

8.1.1. улсын төсвийн хөрөнгө;

8.1.2. орон нутгийн төсвийн хөрөнгө;

8.1.3. хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө;

8.1.4. олон улсын байгууллагын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө;



8.1.5. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;

8.1.6. бусад.

8.2. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлсний үр дүнд 2016 онд дараахь түвшинд хүрсэн байна:

8.2.1. цахим засгийг хөгжүүлэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, ашиглах хууль эрх зүй, бодлого зохицуулалтын таатай орчин бүрдэнэ;

8.2.2. төрийн байгууллагуудын 90-ээс доошгүй хувь нь өндөр хурдны өргөн зурвасын сүлжээнд холбогдсон байна;

8.2.3. Монгол Улс цахим засгийн хөгжлөөрөө дэлхийд эхний 30-д, Ази тивд эхний 6-д орсон байна;

8.2.4. төлбөр, хураамжийг иргэн, аж ахуйн нэгж бүр цахим болон мобайл хэлбэрээр төлөх боломжтой болно;

8.2.5. төрийн захиргааны албан хаагчдын мэдээллийн технологийн чиглэлийн ур чадвар сайжирч цахим засгийн үйл ажиллагаа, үйлчилгээг хэрэгжүүлэхэд бэлтгэгдсэн байна;

8.2.6. цахим хэлбэрт шилжих боломжтой төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэн байна;

8.2.7. цахим засгийн үйлчилгээний хэрэглээ өссөн байна;

8.2.8. иргэн бүр цахим засгийн үйлчилгээг хүртэх боломж бүрдсэн байна;

8.2.9. Монгол Улсын олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ;

8.2.10. төрийн албан хаагчдын ажлын бүтээмж өснө.



Засгийн газрын 2012 оны 101 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**“ЦАХИМ ЗАСАГ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хөрөнгө (сая төг)	Хөрөнгийн эх үүсвэр
I. Цахим засгийг хөгжүүлэх бодлого зохицуулалт:					
Мэдээллийн болон кибер орчны аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, цахим үйлчилгээ үзүүлэх болон контент хөгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах хуулийн төсөл боловсруулж, батлуулах					
1.1	Цахим засгийг хөгжүүлэх бодлого зохицуулалт, Мэдээллийн болон кибер орчны аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, цахим үйлчилгээ үзүүлэх болон контент хөгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах хуулийн төсөл боловсруулж, батлуулах	2012-2014	ХЗДХЯ, МШХХТГ, Тагнуулын ерөнхий газар	5.0	улсын төсөв
1.2	Иргэний хууль, Эрүүгийн хууль, Харилцаа холбооны тухай хууль болон бусад холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах	2012-2013	МШХХТГ, ХЗДХЯ	1.0	улсын төсөв
1.3	Цахим төлбөр тооцоог боловсронгуй болгох эрх зүйн орчинг сайжруулах	2012-2013	МШХХТГ, Монголбанк, ХЗДХЯ, ХХЗХ	1.0	улсын төсөв
1.4	Төрийн өгөгдөл мэдээллийг төрийн байгууллагууд хамтран ашиглах талаар дүрэм, журам боловсруулах	2012-2013	МШХХТГ, төрийн захиргааны байгууллага	1.0	улсын төсөв
1.5	Өгөгдөл хамтран ашиглах, хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлын талаар журам болон нэгдсэн код ашиглах талаар зөвлөмж боловсруулах	2012-2013	МШХХТГ, УСХ	1.0	улсын төсөв
1.6	Төрийн байгууллага хоорондын цахим баримт бичиг солилцооны талаар нэгдсэн журам боловсруулах	2012-2013	МШХХТГ, Архивын ерөнхий газар	1.0	улсын төсөв
1.7	Төрийн удирдах албан тушаалтны тоон гарын үсэг ашиглах талаар журам боловсруулах	2012	МШХХТГ, төрийн захиргааны байгууллага	1.0	улсын төсөв
1.8	Төрийн мэдээллийн санд хандах, түүнийг ашиглах талаар журам боловсруулж төрийн мэдээллийн санг зохион байгуулах зөвлөмж гаргах	2012	МШХХТГ, Үндэсний дата төв	1.0	улсын төсөв

1.9	Төрийн байгууллагуудад ашиглагдах программа хангамж, мэдээллийн системийн боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт болон нэвтрүүлэх талаархи бодлогын чиглэл боловсруулах	2012-2013	МШХХТГ, төрийн байгууллага	5.0	улсын төсөв
1.10	Тухайн салбарын болон байгууллагын мэдээллийн энтерпрайз архитектур боловсруулах	2012-2013	МШХХТГ, төрийн захиргааны төв байгууллага		
1.11	Мэдээллийн технологийн аудит, байгууллагуудын мэдээллийн технологийн хөгжлийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгоход баримтлах бодлогын чиглэл, холбогдох журмыг боловсруулж, нэвтрүүлэх	2012-2013	МШХХТГ, ХХЗХ, Үндэсний аудитын газар, МЖЕГ	1.0	улсын төсөв
1.12	Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах	2012-2013	МШХХТГ, БСШУЯ	20.0	улсын төсөв, олон улсын байгууллагын зээл, тусламж
1.13	Төрийн үйлчилгээг хөдөлгөөнт холбооны сүлжээ ашиглан дамжуулах, түүнийг иргэд хялбар ашиглах бололцоог дэмжсэн зохицуулалтын таатай орчинг бий болгох	2012-2013	МШХХТГ, ХХЗХ		
1.14	Цахим засгийн үйлчилгээг найдвартай, аюулгүй явуулах програмын хангамж, контент хөгжүүлэх асуудлыг дэмжих бодлого зохицуулалтыг бий болгох	2012-2014	МШХХТГ		
1.15	Төрийн мэдээлэл солилцоо болон өгөгдлийг дундаа хамтран ашиглах, төрийн мэдээллийг удирдах зэрэг зохицуулалтыг бий болгох	2012-2013	МШХХТГ, Тагнуулын ерөнхий газар, ХЗДХЯ		
	Нэгдүгээр зорилтын нийт төсөв			38.0	
II. Мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:					
2.1	Засгийн газрын нэгдсэн энтерпрайз архитектур боловсруулж, нэвтрүүлэх	2013-2014	МШХХТГ, бүх шатны төрийн байгууллага	1,500.0	улсын төсөв, Засгийн газрын тусгай сан, орон нутгийн төсөв



2.2	Төрийн байгууллагуудыг холбосон өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх, нөөц сүлжээ үүсгэх	2012-2013	Тагнуулын ерөнхий газар, МШХХТГ	9,000.0	Улсын төсөв, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж эхэлсэн
2.3	Утасгүй өргөн зурвасын сүлжээг бий болгох, өргөтгөх үйл ажиллагааг дэмжих	2012-2014	МШХХТГ, ХХЗХ		Өндөр хурдны өргөн зурвасын үндэсний мэдээллийн сүлжээ хөтөлбөрийн төсөвт тусгагдсан
2.4	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгох	2012-2013	МШХХТГ	500.0	Дэлхийн банкны төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа
2.5	Мэдээллийн нууцлал, хамгаалалтын системийн нэгдсэн төлөвлөлт, дизайн боловсруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2013-2014	МШХХТГ, Тагнуулын ерөнхий газар, бүх шатны төрийн байгууллага	1,000.0	Улсын төсөв
2.6	Программ хангамжийг лицензтэй болгох, программ хангамжийн хууль ёсны хэрэглээг бий болгох	2013-2014	МШХХТГ, төрийн байгууллагууд	8,100.0	Улсын төсөв, олон улсын байгууллагын зээл, тусламж
2.7	Үүлэн тооцооллын технологи нэвтрүүлж эхлэх	2013-2014	МШХХТГ	1,000.0	Улсын төсөв
	Хоёрдугаар зорилтын нийт төсөв			21,100.0	
III. Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох зорилтын хүрээнд:					
3.1	Төрийн байгууллагын вэбсайтын контентийн чанарыг сайжруулах, тухай бүр нь баяжилт, шинэчлэлт хийж хэвшүүлэх	2012-2013	МШХХТГ, бүх шатны төрийн байгууллага		
3.2	Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг илүү хяналттай, өндөр бүтээмжтэй болгох зорилгоор гүйцэтгэлд тулгуурласан үнэлгээний мэдээллийн систем нэвтрүүлэх	2013-2014	МШХХТГ, бүх шатны төрийн байгууллага	3,500.0	Улсын төсөв, орон нутгийн төсөв

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ:

3.3	Эрүүл мэндийн алсын зайн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2012-2016	ЭМЯ, МШХХТГ	Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд хэрэгжиж байна
3.4	Эмнэлэгүүдийг өндөр хурдны сүлжээнд холбох, мэдээлэл (өвчний түүх) солилцох боломжоор хангах	2012-2016	ЭМЯ, МШХХТГ	Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд хэрэгжиж байна
3.5	Өвчлөлтийн тандалт, статистик мэдээллийн сан, мэдээллийн систем бий болгох	2013-2015	ЭМЯ, МШХХТГ	улсын төсөв, олон улсын зээл, тусламж
3.6	Иргэний эрүүл мэндийн даатгалын хяналтын системийг хөгжүүлэх	2013-2015	ЭМЯ, МШХХТГ	улсын төсөв
3.7	Хүнсний болон эмийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналтын систем нэвтрүүлэх	2012-2014	МШХХТГ, ЭМЯ	улсын төсөв

БОЛОВСРОЛЫН САЛБАРТ:

3.8	Цахим номын сан байгуулах	2013-2016	МШХХТГ, БСШУЯ	олон улсын зээл, тусламж
3.9	Сургууль, цэцэрлэгийн багш нарт мэргэжлийн "Тэргүүлэх" зэрэг олгох бүртгэлийн систем бий болгох	2013	БСШУЯ, МШХХТГ	улсын төсөв
3.10	Боловсролын үнэмлэх, гэрчилгээг олгох, нөхөн олгох мэдээллийн систем боловсруулж, нэвтрүүлэх	2013	БСШУЯ, МШХХТГ	улсын төсөв
3.11	Ногоон бүсийн хүүхдийн зуслангийн бүртгэлийн мэдээллийн систем боловсруулж, нэвтрүүлэх	2013	БСШУЯ, МШХХТГ	улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
3.12	Соёл, урлагийн үйл ажиллагаа явуулах гэрчилгээ олгох мэдээллийн систем бий болгох	2012-2013	БСШУЯ, МШХХТГ	улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
3.13	Бүх шатны сургуулиудын бүртгэл, хайлтын систем болон элсэлтийн шалгалтын онлайн систем бий болгох	2012-2016	МШХХТГ, БСШУЯ	улсын төсөв
3.14	Сургуулийн удирдлагын систем нэвтрүүлэх	2012-2016	МШХХТГ, БСШУЯ	улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, олон улсын зээл, тусламж

3.15	Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлэх	2012-2016	МШХХТГ, БШШУЯ	8,760.0	улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, олон улсын зээл, тусламж
3.16	Үндэсний цахим сургалтын удирдлагын цогц систем (МОНСУС, МОНКУС) болон онлайн сургалтыг нэвтрүүлэх	2012-2016	МШХХТГ, БШШУЯ	13,630.0	улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, олон улсын зээл, тусламж
3.17	"Шинэ зууны боловсрол" төслийг хэрэгжүүлэх	2012-2015	БШШУЯ, МШХХТГ	58,000.0	олон улсын зээл, тусламж
УУЛ УУРХАЙН САЛБАРТ:					
3.18	Уул, уурхайн олборлолт, ашиглалт явуулсан талбайн нөхөн сэргээлтийн талаархи мэдээллийн систем бий болгох	2013-2014	ЭБЭХЯ, МШХХТГ, БОАЖЯ, ЦУОШГ	3,000.0	улсын төсөв, олон улсын байгууллагын зээл, тусламж
3.19	Экологийн хохирлын болон нөхөн төлбөр, хураамжийг тооцох, хармицуулах, төлүүлэх, хянах мэдээллийн систем нэвтрүүлэх	2013	МШХХТГ, БОАЖЯ	200.0	улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт
3.20	Улсын болон хувийн хөрөнгөөр хийгдсэн эрдэс баялгийн бүх төрлийн геологийн судалгааны ажлын үр дүнг нэгтгэн боловсруулж, үндэсний геомэдээллийн сан бий болгох	2012-2016	МШХХТГ, ЭБЭХЯ	5,000.0	улсын төсөв, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
3.21	Уул уурхайн кадастрын бүртгэлийн системийг бүрэн автоматжуулах	2012-2016	МШХХТГ, ЭБЭХЯ	2,000.0	улсын төсөв, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа
3.22	Уул уурхайн үйлдвэрлэлийн тээврийн хяналтын систем нэвтрүүлэх	2013-2016	МШХХТГ, ЭБЭХЯ	3,000.0	улсын төсөв, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ:					
3.23	Газар тариалангийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх	2013-2015	ХХААХҮЯ, МШХХТГ	2,000.0	улсын төсөв, орон нутгийн төсөв
3.24	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн цогц шийдэл бүхий програмын хангамж, сүлжээг бий болгох	2012-2014	ХХААХҮЯ, МШХХТГ	3,000.0	улсын төсөв

3.25	Бирхийн мэдээллийн технологийн шаардлагад нийцсэн мэргэжилтнийг орон нутагт бэлтгэх, онлайн сургалтыг нэвтрүүлэх	2012-2013	МШХХТГ, ХХААХҮЯ	500.0	улсын төсөв
3.26	Малын бүртгэл, хөдөлгөөнийг хянахтай холбоотой цогц системийг хөгжүүлэх	2012-2014	МШХХТГ, ХХААХҮЯ	2,500.0	улсын төсөв
3.27	Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний голомт, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүртгэж, онлайн зөвлөгөө өгөх	2012-2013	ХХААХҮЯ, МШХХТГ	350.0	улсын төсөв
3.28	Хүнсний аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн систем үүсгэх	2013-2014	МШХХТГ, ХХААХҮЯ	2,700.0	улсын төсөв
3.29	Худалдааны бүртгэл, мэдээллийн систем бий болгох	2013-2014	МШХХТГ, ХХААХҮЯ	300.0	улсын төсөв
3.30	Хөнгөн үйлдвэрийн салбарт мэдээллийн системийг бий болгох	2013-2014	ХХААХҮЯ, МШХХТГ	200.0	улсын төсөв
ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА:					
3.31	Ашиглалтад орсон болон шинээр баригдах барилга байгууламж, гэр хороолол, тэдгээрийг дулаан, цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх	2013-2014	МШХХТГ, ЗТБХБЯ	300.0	улсын төсөв
3.32	Хотын авто замын дагуух бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, орц, гарц, зогсоолын ажлын төлөвлөлт, трасс сонголт, эдэлбэр газарт барилга барих, зам сэтлэх, зогсоол барих барилгын ажлын зөвшөөрөл олгох зэрэг үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх	2012-2014	МШХХТГ, ЗТБХБЯ	200.0	улсын төсөв
3.33	"Цахим газар" төсөл хэрэгжүүлэх	2012-2015	МШХХТГ, ГХБГЗЗГ	15,000.0	улсын төсөв
3.34	Хотын гадна дүүрэгт оршин суух иргэдийн тээврийн хэрэгсэл нийслэл рүү нэвтрэх үнэмлэхийг онлайнгаар олгох мэдээллийн систем боловсруулж, нэвтрүүлэх	2013-2014	МШХХТГ, ЗТБХБЯ	200.0	улсын төсөв
3.35	Авто зам, замын байгууламжтай холбоотой өргөдөл, хүсэлт, санал, гомдлыг хүлээн авах, барагдуулах мэдээллийн систем боловсруулж, нэвтрүүлэх	2012-2014	МШХХТГ, ЗТБХБЯ	100.0	улсын төсөв



3.36	Тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд шинээр бүртгэх, гэрчилгээг нөхөн олгох, улсын дугаар солих, нөхөн олгох, шилжүүлэх, улсын үзлэг тоологод оруулах, гадаад оронд байнга буюу удаан хугацаагаар ашиглах тээврийн хэрэгсэлд явуулын дугаар, түр гэрчилгээ олгох зэрэг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх	2012-2014	МШХХТГ, ЗТБХБЯ	1,000.0	улсын төсөв
3.37	Хаяж үрэгдүүлсэн жолооны үнэмлэх нөхөн олгох, автомашин жолоодох эрх сэргээх мэдээллийн систем бий болгох	2012-2013	МШХХТГ, ЗТБХБЯ	100.0	улсын төсөв
3.38	Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрхийн үнэмлэх олгох мэдээллийн систем бий болгох	2013	МШХХТГ, ЗТБХБЯ	100.0	улсын төсөв
3.39	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох мэдээллийн систем бий болгох	2013	МШХХТГ, ЗТБХБЯ	100.0	улсын төсөв
3.40	Зорчигч тээврийн хэрэгслийн тасалбар борлуулах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх мэдээллийн систем бий болгох	2013	МШХХТГ, ЗТБХБЯ	1,000.0	улсын төсөв
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, ЛАВЛАГАА ОЛГОХ:					
3.41	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгож байгаа зарим тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд бүрэн шилжүүлэх	2013-2014	МШХХТГ, тусгай зөвшөөрөл олгодог байгууллага	2,000.0	улсын төсөв, Засгийн газрын тусгай сан
3.42	Жижиг, дунд үйлдвэрлэл, шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох мэдээллийн систем бий болгох	2013-2014	МШХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	200.0	улсын төсөв
3.43	Реклам болон мэдээллийн байгууламж байршуулах зөвшөөрөл олгох мэдээллийн систем бий болгох	2013-2014	МШХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	100.0	улсын төсөв, орон нутгийн төсөв
3.44	Архивын лавлагаа олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх	2013-2015	МШХХТГ, яам, ЗГ-ын агентлаг	8,000.0	улсын төсөв, орон нутгийн төсөв
3.45	Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ шинээр олгох, шилжүүлэх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх	2013-2015	МШХХТГ, УБЕГ	1,000.0	улсын төсөв

БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРТ:				
3.46	Санхүүгийн үйл ажиллагааг дэмжих мэдээллийн системийг хөгжүүлэх	2013-2014	МШХХТГ, СЯ, Монголбанк, СЗХ	улсын төсөв
НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН САЛБАРТ:				
3.47	Нийгмийн халамжийн бүх төрлийн үйлчилгээний цогц цахим системийг хөгжүүлэх	2013-2015	МШХХТГ, НХХЯ	улсын төсөв, орон нутгийн төсөв
3.48	Хөдөлмөрийн биржийн цогц шийдэл бүхий онлайн системд орон нутгийг хамруулан өргөтгөж, хөгжүүлэх	2012-2013	МШХХТГ, НХХЯ	Улсын төсөв, Засгийн газрын тусгай сан
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:				
3.49	Төрийн албаны хүний нөөцийн үндэсний хэмжээний мэдээллийн систем бий болгох	2013-2014	МШХХТГ, ТАЗ	улсын төсөв
3.50	Төрийн албаны бодлогын мэдээлэл, дүн шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэдээллийн систем нэвтрүүлэх	2013-2014	ТАЗ, МШХХТГ	улсын төсөв
БАГ, ХОРООНООС ИРГЭДЭД ХҮРГЭДЭГ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛАХ:				
3.51	Цэргийн үүрэгтний бүртгэлийн мэдээллийн системийг бий болгох	2012-2013	МШХХТГ, дүүрэг, баг, хорооны Засаг дарга	улсын төсөв
3.52	Иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой цогц системийг хөгжүүлэх	2012-2013	МШХХТГ, УБЕГ, бүх шатны Засаг дарга	улсын төсөв, орон нутгийн төсөв
3.53	Төрөөс засаг захиргааны анхан шатны нэгжээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээ, мэдээ мэдээллийг хүргэхэд цахим шуудангийн хайрцаг болон мэдрэгч бүхий технологийг нэвтрүүлж эхлэх	2013-2016	МШХХТГ, УБЕГ, бүх шатны Засаг дарга	улсын төсөв, орон нутгийн төсөв
БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭ:				
3.54	Үндэсний дата төв рүү байгууллагын мэдээллийн системийг шилжүүлэн төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэх	2013	МШХХТГ	улсын төсөв, олон улсын зээл, тусламж

3.55	Иргэний бүртгэл, эд хөрөнгийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээнд "Ухаалаг дараалал систем"-ийг нэвтрүүлэх	2013-2014	МШХХТГ, УБЕГ	500.0	улсын төсөв, олон улсын зээл, тусламж
3.56	Үндэсний дата төвийн нөөц төвийг байгуулахад дэмжлэг үзүүлэх	2013-2014	МШХХТГ	12,000.0	улсын төсөв, олон улсын зээл, тусламж
3.57	Бүх төрлийн даатгалын үйлчилгээнд иргэний цахим үнэмлэхийг хэрэглэх боломжийг бүрдүүлэх	2012-2013	МШХХТГ	5,000.0	улсын төсөв
3.58	Цахим засгийн үндэсний портал систем, платформ бий болгох	2012-2013	МШХХТГ	800.0	Дэлхийн банкны төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа
3.59	Нийтийн түлхүүрийн дэд бүтэц, цахим гарын үсгийн хэрэглээг иргэний цахим үнэмлэхтэй холбон өгч банкны үйлчилгээ, бусад аюулгүй байдлын өндөр түвшин шаардсан хэрэглээг бий болгох	2013-2014	МШХХТГ	1,500.0	улсын төсөв
3.60	Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас зөвлөсөн "Цахим гадаад паспорт"-ыг Монгол Улсын хэрэглээнд нэвтрүүлэх	2013-2015	МШХХТГ	12,000.0	улсын төсөв
3.61	Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж байгаа явцыг хянах нэгдсэн мэдээллийн систем бий болгох	2012-2014	МШХХТГ	2,000.0	улсын төсөв
ИРГЭНИЙ ЦАХИМ ҮНЭМЛЭХ УНШИГЧ, ХОЛБОГДОХ БУСАД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ НИЙЛҮҮЛЭХ:					
3.62	Эрүүл мэндийн салбарт	2012	МШХХТГ, ЭМЯ	2,279.1	улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт
3.63	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын салбарын үйлчилгээнд	2012	МШХХТГ, ЗТБХБЯ	1,635.7	улсын төсөв
3.64	Иргэний бүртгэлийн үйлчилгээнд	2012-2013	МШХХТГ, УБЕГ, дүүрэг, хороо, сум, баг	1,089.1	улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт
3.65	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээнд	2012	МШХХТГ, УБЕГ	852.7	улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт
3.66	Хуулийн этгээдийн эрхийн бүртгэлийн үйлчилгээнд	2012	МШХХТГ, УБЕГ	994.5	улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт

3.67	Нийгмийн халамжийн үйлчилгээнд	2012	МШХХТГ, НХХЯ	1,256.2	улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт	
3.68	Нийгмийн даатгалд	2012	МШХХТГ, НДЕГ	1,050.0	улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт	
3.69	Цагдаагийн үйлчилгээнд	2012	МШХХТГ, ХЗДХЯ	2,826.2	улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт	
3.70	Татварын үйлчилгээнд	2012	МШХХТГ, Татварын ерөнхий газар	951.5	улсын төсөв, гадаадын зээл, тусламж	
3.71	Гаалийн үйлчилгээнд	2012	МШХХТГ, ГЕГ	937.0	улсын төсөв, гадаадын зээл, тусламж	
3.72	Дипломат төлөөлөгчийн газрын үйлчилгээнд	2012	МШХХТГ, ГХЯ	1,364.2	улсын төсөв, гадаадын зээл, тусламж	
ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БИЙ БОЛГОХ:						
3.73	Гэмт халдлага, байгалийн гамшиг, малын онц халдварт өвчнийг мэдээлэх	2013-2014	МШХХТГ, ОБЕГ	100.0	улсын төсөв	
3.74	Шуурхай удирдлагын төвийг мессежтэй болгох	2013	МШХХТГ, НЗДТГ	100.0	улсын төсөв	
3.75	Номын сангийн үйлчилгээний мэдээллийг хүргэх	2013-2014	МШХХТГ, БШШУЯ	200.0	улсын төсөв, Засгийн газрын тусгай сан	
3.76	Хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн иргэдэд мэдээ хүргэх	2013	МШХХТГ, НХХЯ	200.0	улсын төсөв, Засгийн газрын тусгай сан	
3.77	Замын хөдөлгөөний мэдээллийг хүргэх	2013	МШХХТГ, ЗЦГ	200.0	улсын төсөв, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж	
3.78	Ор сураггүй болсон хүн, гэмт хэрэгтнийг эрэн сураалжлах мэдээллийг такси, автобусны жолооч нарт илгээх	2013-2014	МШХХТГ, ЦЕГ	300.0	улсын төсөв	

3.79	Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг мессежээр илгээх	2013	МШХХТГ, БСШУЯ	200.0	Улсын төсөв, Засгийн газрын тусгай сан
3.80	Жуулчдад зориулсан үйлчилгээний мэдээлэл хүргэх	2013-2014	МШХХТГ, БОАЖЯ, НЗДТГ	300.0	улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
3.81	Эмнэлгийн үзлэгийн бүртгэлийн цагийг мэдээлэх	2012-2014	МШХХТГ, ЭМЯ	200.0	улсын төсөв, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж
3.82	Тээврийн хэрэгслийн торгууль, орон сууцны төлбөрийн тухай мэдээллийг хүргэх	2014-2015	МШХХТГ, ЗЦГ, ОСНААГ	200.0	улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
3.83	Нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийг хүргэх	2013-2014	МШХХТГ, НХХЯ	200.0	Улсын төсөв, орон нутгийн төсөв
3.84	Малчдад түүхий эдийн үнэ, ханш илгээх	2012-2013	МШХХТГ, ХХААХУЯ	300.0	улсын төсөв
3.85	Тендерийн мэдээлэл, лавлагаа	2013	МШХХТГ, СЯ	200.0	улсын төсөв
3.86	Татварын лавлагаа	2012-2014	МШХХТГ, Татварын ерөнхий газар	300.0	улсын төсөв
3.87	Хөрөнгө орлогын мэдүүлэг авах хугацаа дуусах тухай мэдээлэх, зөвлөгөө өгөх	2013	МШХХТГ, АТГ	150.0	улсын төсөв
3.88	Төрийн албан хаагчдын шалгалтын зар, шалгалтын дүнг мэдээлэх	2013-2014	МШХХТГ, ТАЗ	150.0	улсын төсөв
3.89	Замын цагдаагийн мэдээлэл түгээх	2014-2015	МШХХТГ, ЗЦГ	300.0	улсын төсөв
3.90	Банкны үйлчилгээний төлбөр тооцоо, дансны мэдээлэл хүргэх	2014-2016	МШХХТГ, Монголбанк	1,500.0	улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
3.91	Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл, лавлагааны систем	2012	МШХХТГ, УБЕГ	500.0	улсын төсөв
3.92	Мэргэжлийн хяналтын шалгалтын мэдээлэл, лавлагааны систем	2012-2013	МШХХТГ, МХЕГ	500.0	улсын төсөв

3.93	Иргэдэд үйлчлэх үйлчилгээний газрын байршил, цагийн хуваарийн мэдээлэл хүргэх	2013-2014	МШХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	500.0	улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
3.94	Улаанбаатар хотын агаарын бохирдлын тухай мэдээлэл хүргэх	2014	МШХХТГ, НЗДТГ	300.0	улсын төсөв
3.95	Тээврийн хяналтын систем	2014-2016	МШХХТГ, ЗТБХБЯ	300.0	улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
3.96	Улсын тэмдэгтийн хураамж төлөх	2013	МШХХТГ, Монголбанк	500.0	улсын төсөв
3.97	Хөдөлгөөнт холбооны технологид суурилсан төрийн үйлчилгээг бий болгох чиглэлийн судалгаа шинжилгээний ажлыг дэмжих	2012-2014	МШХХТГ, БСШУЯ	500.0	улсын төсөв, Засгийн газрын тусгай сан
3.98	Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад иргэд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, иргэдийн оролцоог хангах	2012-2016	МШХХТГ, бүх шатны төрийн байгууллагууд	500.0	улсын төсөв
3.99	Мэдээллийн технологийн нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулж, түүгээр дамжуулан цахим засгийн үйлчилгээг иргэдэд хүргэх	2012-2016	МШХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	60,000.0	улсын төсөв, орон нутгийн төсөв
	Гуравдугаар зорилтын нийт төсөв			296,985.9	
Ү. Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, иргэдэд төрийн цахим үйлчилгээг ашиглах мэдлэг олгох зорилтын хүрээнд:					
4.1	Төрийн албан хаагчдад зориулсан мэдээллийн технологийн сургалтын төвийг байгуулах, төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн ур чадварын түвшинг тогтоох тогтолцоог бий болгох	2013-2014	МШХХТГ, төрийн байгууллагууд	7,200.0	улсын төсөв, Засгийн газрын тусгай сан
4.2	Мэдээллийн технологийн мэргэжилтэн, мэргэжлийн багш нарын мэдлэг, ур чадварыг олон улсын түвшинд хүргэх, хөдөө орон нутагт мэргэжлийн боловсон хүчнээр хангах	2013-2016	БСШУЯ, МШХХТГ	20,000.0	улсын төсөв, олон улсын байгууллагын зээл, тусламж

4.3	Төрийн байгууллагад ажиллаж байгаа мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ур чадварыг сайжруулах, тогтвортой ажиллуулах урамшууллын механизмыг бий болгох	2013-2016	МШХХТГ, ТАЗ	5.0	улсын төсөв
4.4	Мэдээллийн технологийн нарийн мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх	2013-2016	БСШУЯ, МШХХТГ	10,000.0	улсын төсөв, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
4.5	Цахим засгийг хөгжүүлэх зорилготой судалгаа шинжилгээний төвийг байгуулах	2013-2014	МШХХТГ, ЗГХЭГ, ХХЗХ	10,000.0	улсын төсөв, Засгийн газрын тусгай сан
4.6	Иргэд болон төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалт, сургалтын агуулгад аудио, видео дүрс ашигласан контент бүхий цахим сургалтыг түлхүү дэмжих, хэвлэл мэдээллийн бүх сувгийг (интернэт, радио, телевиз гэх мэт) ашиглах	2012-2016	МШХХТГ, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, их, дээд сургуулиуд	900.0	улсын төсөв, олон улсын байгууллагын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
4.7	Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт мэдээллийн технологийн сургалтын агуулгыг нэмэгдүүлэх	2012-2016	МШХХТГ, БСШУЯ	5.0	улсын төсөв
4.8	Гэрийн ажилтай эмэгтэйчүүд, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандсан цахим болон явуулын сургалтыг зохион байгуулна	2013-2016	МШХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	500.0	улсын төсөв, орон нутгийн төсөв, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж
	Дөрөвдүгээр зорилтын нийт төсөв			48,610.0	
	НИЙТ ТӨСӨВ			366,733.9	



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 131

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх онц чухал объектын жагсаалт”-ын “Дотоодын цэргийн гэрээт хамгаалалтад байх объектууд” гэсэн Хоёр дахь хэсэгт “6.Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах 18 мгв-ын цахилгаан станц, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж” гэж нэмсүгэй.

2. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах 18 мгв-ын цахилгаан станц, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг Дотоодын цэргийн гэрээт хамгаалалтад шилжүүлсэнтэй холбогдуулан зохих гэрээ байгуулж, хамгаалалтыг зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 133

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16.10-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журмыг



хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Д.Хаянхярваа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн бүх шатны байгууллагын удирдлагад, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэ тогтоолыг 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2012 оны 133 дугаар
тогтоолын хавсралт

**АЛБАН ТУШААЛТНЫ ТӨРИЙН ӨМЧЛӨЛД ШИЛЖҮҮЛСЭН
БЭЛЭГ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ, ХӨЛСИЙГ ҮНЭЛЭХ,
ХАДГАЛАХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар албан тушаалтны 6 сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн үнийн дүн бүхий бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг төрийн өмчид шилжүүлэх, тэдгээрийг үнэлэх, хадгалах, зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмыг буцаан хэрэглэхгүй бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдөр буюу 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журам нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4.1-д заасан албан тушаалтанд үйлчилнэ.

1.4. Албан тушаалтанд үзүүлсэн дараахь үйлчилгээнд энэхүү журмыг дагаж мөрдөнө:



1.4.1. албан тушаалтны 6 сарын цалингаас хэтэрсэн үнэ, хөлс бүхий үйлчилгээг албан тушаалтанд үнэ төлбөргүй үзүүлсэн бол;

1.4.2. албан тушаалтанд үзүүлсэн үйлчилгээний үнэ, хөлсний нийт хөнгөлөлт нь албан тушаалтны 6 сарын цалингаас илүү гарсан бол.

1.5. Албан тушаалтнаас төрийн өмчид шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах чиг үүргийг энэхүү журмын 3.1-д заасан орон тооны бус Комисс (цаашид “Комисс” гэх) эрхэлнэ.

Хоёр. Бэлгийг мэдүүлэх

2.1. Энэхүү журамд өөрөөр заагаагүй бол албан тушаалтны 6 сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн үнийн дүн бүхий бэлгийг төрийн өмчлөлд шилжүүлнэ.

2.2. Энэхүү журмын 1.5-д заасан үйлчилгээний үнэ, хөлсийг албан тушаалтан мөнгөн дүнгээр илэрхийлж төрийн өмчлөлд шилжүүлнэ.

2.3. Албан тушаалтан хүлээн авсан бэлэг, үйлчилгээ (цаашид “бэлэг” гэх)-г төрийн өмчлөлд шилжүүлэх мэдүүлгийг энэхүү журмын хавсралтаар баталсан маягтын дагуу гаргаж тухайн байгууллагын Тамгын газар (захиргааны хэлтэс)-т хүлээлгэн өгнө.

2.4. Албан тушаалтан мэдүүлэгт бэлгийг хавсаргана.

2.5. Албан тушаалтны мэдүүлэг болон бэлгийг хүлээн авч Комисст хүргэх үүргийг тухайн байгууллагын Тамгын газар (захиргааны хэлтэс) хариуцан гүйцэтгэнэ.

2.6. Албан тушаалтан бэлэг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор мэдүүлгийг гаргана.

Гурав. Комисс, түүний бүрэлдэхүүн

3.1. Комиссыг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулна.

3.2. Комисс 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын бүрэлдэхүүнд дараахь байгууллагын төлөөллийг оруулна:



- 3.2.1. Улсын Их Хурлын Тамгын газар;
- 3.2.2. Ерөнхийлөгчийн Тамгын газар;
- 3.2.3. Шүүхийн ерөнхий зөвлөл;
- 3.2.4. Гадаад харилцааны яам;
- 3.2.5. Сангийн яам;
- 3.2.6. Төрийн ёслолын алба;
- 3.2.7. Авлигатай тэмцэх газар;
- 3.2.8. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;
- 3.2.9. төрийн бус байгууллага (3 хүн).

3.3. Комиссын даргыг гишүүд дундаасаа нэг жилийн хугацаатай сонгоно. Комиссын даргыг улируулан сонгохгүй.

3.4. Комиссын ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхий сайд батална.

Дөрөв. Бэлэг үнэлэх

4.1. Комисс албан тушаалтны гаргасан мэдүүлэгтэй танилцаж бэлгийг үнэлнэ.

4.2. Комисс нь уг бэлэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг холбогдох төрийн байгууллага болон тухайн албан тушаалтнаас гаргуулах, шаардлагатай тохиолдолд шалган тайлбар, тодруулга авч болно.

4.3. Мөнгөн бус хэлбэрийн бэлгийг үнэлэхдээ зах зээлийн үнэ, ханшийг харгалзан тогтооно. Үнэлэхэд хүндрэлтэй бэлэгний үнийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу мэргэжлийн үнэлгээнээр тогтоолгож болно.

4.4. Комисс тухайн бэлэг нь түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарч болзошгүй гэж үзсэн тохиолдолд соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн зөвлөлд хандаж дүгнэлт гаргуулна.

4.5. Бэлэгний үнэ албан тушаалтны 6 сарын цалингийн хэмжээнээс хэтрээгүй болох нь үнэлгээгээр тогтоогдвол Комисс бэлгийг бүртгэлд оруулахгүйгээр тухайн албан тушаалтанд буцаан олгох шийдвэр гаргана.

Тав. Бэлэг хадгалах

5.1. Бэлгийг үнэлсний дараа бүртгэлд оруулж зориулалтын байранд хадгална. Мөнгөн хэлбэрийн бэлгийг төсвийн асуудал хариуцсан



төрийн захиргааны төв байгууллагын нээсэн Төрийн сангийн зохих дансанд байршуулна.

5.2. Эрдэнэсийн сан хөмрөгт орох үнэт эдлэл, түүх, соёлын дурсгалт зүйлийг зохих журмын дагуу эрдэнэсийн сан, үндэсний музей болон холбогдох бусад соёлын байгууллагад хадгалуулах шийдвэр гаргаж болно.

5.3. Хадгалалтын хугацаа дууссан, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон, холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор хөнөөлтэй болох нь тогтоогдсон зэрэг шалтгааны улмаас бэлгийг хадгалах, захиран зарцуулах, ашиглах боломжгүй тохиолдолд баримт үйлдэн устгаж болно.

Зургаа. Бэлгийг зарцуулах

6.1. Комисс бүртгэлд оруулсан бэлгийг зарцуулах талаар дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

6.1.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16.6-д заасны дагуу 6 сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн үнийн зөрүүг төлүүлж, бэлэг хүлээн авсан албан тушаалтны өмчлөлд буцаан олгох;

6.1.2. бэлэг хүлээн авсан албан тушаалтан ажилладаг буюу харьяа байгууллагын хэрэгцээнд үнэ төлбөргүй шилжүүлэх;

6.1.3. төрийн болон нутгийн захиргааны бусад байгууллагын хэрэгцээнд үнэ төлбөргүй шилжүүлэх;

6.1.4. энэ журмын 5.2-т заасан холбогдох байгууллагад хадгалуулахаар үнэ төлбөргүй шилжүүлэх;

6.1.5. дуудлага худалдаагаар борлуулах;

6.1.6. баримт үйлдэн устгах.

6.2. Комисс бэлгийг зарцуулахтай холбогдуулан гаргасан шийдвэрийг мэдүүлэг гаргасан албан тушаалтанд мэдэгдэж биелэлтэд хяналт тавина.



6.3. Энэхүү журмын 6.1.5-д заасан дуудлага худалдааг Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан журмыг баримтлан зохион байгуулж орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

Долоо. Албан тушаалтны өмчлөлд бэлгийг буцаан олгох

7.1. Албан тушаалтан 6 сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн үнийн зөрүүг төлж бэлгийг өөртөө үлдээх санал гаргаж болох бөгөөд энэ тухай мэдүүлэгт тусгана.

7.2. Албан тушаалтан бэлэгний үнийн зөрүүг төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын нээсэн Төрийн сангийн зохих дансанд шилжүүлнэ.

7.3. Бэлэгний үнийн зөрүүг төлсөн баримтыг үндэслэн Комисс бэлгийг албан тушаалтны өмчлөлд шилжүүлж энэ тухай бүртгэлд тэмдэглэл хийнэ.

Найм. Бусад

8.1. Комисс төрийн өмчид шилжүүлсэн бэлэгний талаар мэдээллийн сан хөтөлнө.

8.2. Комисс нь энэхүү журмын хэрэгжилтийн тайланг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28.1.1, 28.1.2-т заасан байгууллагад жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор хүргүүлнэ.

8.3. Энэхүү журмын 8.2-т заасан тайлан нийтэд нээлттэй байх бөгөөд Комисс түүнийг цахим хуудас болон бусад хэлбэрээр нийтэд ил тод мэдээлнэ.

8.4. Бэлгийг үнэлэх, зарцуулах асуудлаар Комиссын гаргасан шийдвэртэй холбоотой гомдлыг шүүхэд гаргаж болно.

8.5. Албан тушаалтан энэхүү журмын заалтыг зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.



Журмын хавсралт

**АЛБАН ТУШААЛТНЫ ТӨРИЙН ӨМЧЛӨЛД
ШИЛЖҮҮЛСЭН БЭЛЭГ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ,
ХӨЛСНИЙ ТАЛААРХИ МЭДҮҮЛЭГ**

Мэдүүлэг гаргагчийн бөглөх хэсэг

_____ -ын _____ -Т
(төрийн байгууллагын нэр) (нэгжийн нэр)

_____ -тай _____
(албан тушаалын нэр) (ургийн овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр)

миний албан үүрэгтэйгээ холбогдолгүйгээр хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16.5-д заасны дагуу албан тушаалын 6 сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн тул төрийн өмчлөлд шилжүүлж байна.

1. Бэлэгний төрөл:

- Хөдлөх хөрөнгө Үл хөдлөх хөрөнгө
- Бэлэн мөнгө Түүх, урлаг соёлын дурсгалт зүйл
- Үйлчилгээ (эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, эрхээс татгалзах, бусад)
- Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх шагнал

2. Бэлэгний тодорхойлолт (хэлбэр, хэмжээ):

3. Бэлэгний эх сурвалж (хэн, ямар шалтгаанаар, хаана өгсөн)

4. Бэлэг хүлээн авсан огноо: _____

5. Бэлэгний үнэлгээ: _____

Бэлэгний үнэ (мөнгөн дүн) _____

Өөрөө үнэлсэн Тусгай байгууллагаар үнэлэгдсэн

Тайлбар (бэлэгний үнэ тодорхой бус тохиолдолд өөрөө үнэлсэн, эсхүл тусгай байгууллагаар үнэлүүлсэн талаар тайлбарлана) _____



6. Бэлгийг өөртөө авах хүсэлтэй эсэх:

Тийм

Үгүй

7. Бэлгийг төрийн өмчлөлд шилжүүлсэн тухай мэдээлэл:

_____ (нэр)

_____ (гарын үсэг)

_____ (огноо)

Холбогдох байгууллагын Тамгын газар (захиргааны хэлтэс)-ын ажилтны бөглөх хэсэг

8. Мэдүүлгийг хүлээн авсан талаархи тэмдэглэл:

_____ (нэр)

_____ (гарын үсэг)

_____ (огноо)

9. Нийтийн албан тушаалтнаас төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлгийг үнэлэх, хадгалах, зарцуулах асуудлыг эрхэлсэн орон тооны бус Комисст (цаашид "Комисс" гэх) шилжүүлсэн талаархи тэмдэглэл:

_____ (нэр)

_____ (гарын үсэг)

_____ (огноо)

Комиссын бөглөх хэсэг

10. Комисс хүлээн авсан талаархи тэмдэглэл:

_____ (нэр)

_____ (гарын үсэг)

_____ (огноо)

11. Төрийн өмчлөлд шилжүүлэх шаардлагатай эсэх:

Тийм

Үгүй

Тийм бол

(Албан тушаалтны төрийн өмчлөл шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журмыг "Дөрөв"-ийн 4.1-4.4-т заасны дагуу үнэлнэ)

Бэлэгний үнэ (мөнгөн дүн) _____

Комисс үнэлсэн

Үнэлгээчин үнэлсэн

Тайлбар (бэлэгний талаар холбогдох төрийн байгууллага болон албан тушаалтнаас нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга авсан эсэх, бэлгийг үнэлсэн талаархи танилцуулга) _____



12. Бэлгийг хадгалах талаархи Комиссын шийдвэр:

Зориулалтын байранд

Үндэсний музей

Төрийн сангийн зохих дансанд Орон нутгийн музей, үзмэрийн газар

13. Бэлгийг зарцуулах талаархи Комиссын шийдвэр:

бэлэг хүлээн авсан албан тушаалтны харьяалах байгууллагын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлэх

төрийн болон нутгийн захиргааны бусад байгууллагын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлэх

“Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журам”-ын 5.2-т заасан холбогдох байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлэх

6 сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн үнийн зөрүүг төлүүлж, бэлэг хүлээн авсан албан тушаалтанд хүлээлгэн өгөх

баримт үйлдэн устгах

дуудлага худалдаагаар борлуулах

Тайлбар (Бэлгийг устгахдаа Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журмын 5.3-т заасныг баримтлах бөгөөд энэ талаар дор тайлбарлана)

14. Баталгаажуулалтын хэсэг:

(Комиссын даргын нэр)

(гарын үсэг)

(огноо)

(тэмдэг)

Тайлбар (Шийдвэрт Комиссыг төлөөлөн дарга гарын үсэг зурна)



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 136

Улаанбаатар
хот

Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай

Газрын тухай хуулийн 18.1.2, Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санамж бичгийн дагуу Говь-Алтай аймгийн Тайшир, Дорноговь аймгийн Эрдэнэ, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нутаг дэвсгэрт байгуулагдсан газар хөдлөлтийг судлах “ERMAR”, “ALMAR”, “DOMAR” сүлжээ станц байрладаг газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, талбайн хэмжээ, солбицлыг хавсралт ёсоор баталсугай.

2. Улсын тусгай хэрэгцээнд авсан газрын талбайг кадастрын зураг зүйн бүртгэл болон мэдээллийн санд оруулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.

3. Тусгай хэрэгцээнд авсан газрын талбайтай бүхэлдээ болон хэсэгчлэн давхацсан ашигт малтмалын хайгуулын талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээр нөхөн сэргээлт хийлгэж зохих журмын дагуу хүлээж авах ажлыг зохион байгуулахыг Говь-Алтай, Дорнод, Дорноговь аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Ц.ДАШДОРЖ



Засгийн газрын 2012 оны 136 дугаар
тогтоолын хавсралт

**УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД АВАХ ГАЗРЫН
ТАЛБAYН ХЭМЖЭЭ, СОЛБИЦОЛ**

№	Талбайн нэр	Аймаг, сумын нэр	Солбицлууд		Тусгай хэрэгцээнд авах газрын талбайн хэмжээ (га)	Тусгай хэрэгцээнд авсан зорилго
1	"ERMAR"	Дорноговь аймгийн Эрдэнэ сум	44 01 28.5462 44 05 45.4792 44 05 27.8274 44 01 10.3544	110 48 51.7276 110 49 17.6888 110 55 09.9967 110 54 44.9849	6265.147	Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд байгуулсан Санамж бичгийн дагуу газар хөдлөлтийг бүртгэх чичирхийллийн станц байгуулж, үйл ажиллагаа явуулах
2	"ALMAR"	Говь-Алтай аймгийн Тайшир сум	46 32 54.4802 46 38 01.1409 46 38 32.1836 46 33 24.6388	96 21 10.2242 96 20 21.0384 96 27 00.0413 96 27 48.7425	8155.6325	
3	"DOMAR"	Дорнод аймгийн Хөлөнбуйр сум	47 43 17.6119 47 43 44.2907 47 39 34.8400 47 39 08.6268	113 07 13.3033 113 01 03.6576 113 00 24.4313 113 06 35.1842	6017.43	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 137

Улаанбаатар
хот

**Хөдөө аж ахуйн ээлжит тооллого
явуулах тухай**

Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн ээлжит тооллого, судалгааг 2012 оны 5 дугаар сарын 25-наас 2012 оны 6 дугаар сарын 15-ны хооронд явуулахаар тогтоосугай.

2. Хөдөө аж ахуйн ээлжит тооллого Зохион байгуулах комиссыг хавсралт ёсоор баталсугай.

3. Хөдөө аж ахуйн ээлжит тооллого, судалгаа явуулахтай холбогдуулан харьяа нутаг дэвсгэртээ тооллого явуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулах арга хэмжээ авч, тооллогын ажилд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.



4. Тооллогын дүнг нэгтгэн 2013 оны эхний хагас жилд багтаан Засгийн газарт танилцуулахыг Зохион байгуулах комисст даалгаж, Үндэсний статистикийн хороонд зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

Засгийн газрын 2012 оны 137 дугаар
тогтоолын хавсралт

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭЭЛЖИТ ТООЛЛОГО
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

Дарга

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

Орлогч дарга

-Үндэсний статистикийн хорооны дарга

Гишүүд:

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
Төрийн нарийн бичгийн дарга;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны
Төрийн нарийн бичгийн дарга;

-Газрын харилцаа, барилга, геодези, зураг
зүйн газрын дарга;

-Үндэсний статистикийн хорооны Макро эдийн
засгийн статистикийн газрын дарга;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Стратегийн төлөвлөлт, бодлогын газрын дарга;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний
газрын дарга.

**Нарийн бичгийн
дарга**

-Үндэсний статистикийн хорооны Макро эдийн
засгийн статистикийн газрын орлогч дарга.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turii_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 14003